

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь гэр бүлийн хэргийг шүүх хянан шийдвэрлэх, эвлэрүүлэн зуучлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль тогтоомж

2.1.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль,¹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль,² Гэр бүлийн тухай хууль,³ Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль,⁴ энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Гэр бүлийн хэргийг энэ хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу хянан шийдвэрлэнэ.

3.2.Гэр бүлийн хэргийг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд заасны дагуу шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд эвлэрүүлэн зуучлахтай холбоотой харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.

4 дүгээр зүйл.Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэх зарчим

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

³ Гэр бүлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1999 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

4.1.Гэр бүлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3,4,5,6 дугаар зүйлд заасан зарчмаас гадна насанд хүрээгүй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах зарчмыг баримтална.

4.2.Шүүх гэр бүлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хөдөлмөрийн чадваргүй, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэр бүлийн гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан үзнэ.

4.3.Эцэг, эх, эсхүл тэдгээрийн аль нэгний асрамжид байгаа 14 нас хүрсэн хүүхэд, эсхүл сум, хорооны Засаг дарга, гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан, хүүхдийн суралцдаг сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн ажиллагааны талаар шүүх шийдвэрээ гаргахаас өмнө хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүхэд гомдол, хүсэлт гаргах эрхтэй.

4.4.Энэ хуулийн 4.2-т заасан этгээд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндсөн хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхтэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ

5 дугаар зүйл.Гэр бүлийн хэргийн харьяалал

5.1.Гэр бүлийн болон түүнтэй холбоотой харилцаанаас үүссэн дараах маргааныг шүүх харьяалан шийдвэрлэнэ:

5.1.1.гэрлэлттэй холбоотой маргаан;

5.1.2.эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаанаас үүссэн маргаан;

5.1.3.эцэг, эх байх эрхтэй холбоотой маргаан;

5.1.4.хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой маргаан;

5.1.5.тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбоотой маргаан;

5.1.6.хүүхэд үрчлэлттэй холбоотой маргаан;

5.1.7.асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбоотой маргаан;

5.1.8.хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхтэй холбоотой маргаан;

5.1.9.гэр бүлийн эд хөрөнгөтэй холбоотой маргаан;

5.1.10.гэр бүлийн холбогдолтой бусад маргаан;

5.1.11.хамтран амьдрахтай холбоотой маргаан.

6 дугаар зүйл.Гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх

6.1.Шүүх онцгой ажиллагааны журмаар дараах гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэнэ:

6.1.1.энэ хуулийн 6.2-т заасан эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох;

6.1.2.хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах;
6.1.3.сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй гэж тооцуулах болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох;

6.1.4.асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох;

6.1.5.хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох;

6.1.6.асран хүмүүжүүлэх байгууллагад болон асран хүмүүжүүлэгчид шилжсэн хүүхэд, нийгмийн халамжийн байгууллагад шилжсэн хүний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчид хариуцуулах.

6.2.Эрх зүйн ач холбогдол бүхий дараах үйл явдлыг шүүх тогтоохдоо онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ:

6.2.1.садан, төрлийн холбоо байгаа эсэх;

6.2.2.бусдын асрамжинд байгаа эсэх;

6.2.3.хүүхдийн эцэг, эхийг тогтоолгох.

6.2.5.эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, эсхүл сэргээх;

6.2.6.гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох.

6.3.Энэ хуулийн 6.1, 6.2-т заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэхээс бусад гэр бүлийн хэргийг шүүх ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

6.4.Гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлтэй хамт гэм хор, нөхөн төлбөр гаргуулах нэхэмжлэл гаргасан бол гэр бүлийн хэрэгтэй хамт шүүх шийдвэрлэнэ.

6.5.Өв залгамжлалын харилцаанаас үүссэн маргаан нь гэр бүлийн хэрэгт хамаарахгүй.

7 дугаар зүйл.Гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал

7.1.Энэ хуульд заасан гэр бүлийн хэргийг Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

7.2.Энэ хуулийн 7.1-д зааснаас бусад тохиолдолд гэр бүлийн хэргийг тухайн нутаг дэвсгэр дэх анхан шатны шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

7.3.Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх энэ хуулийн 7.1-д заасан Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн харьяалах гэр бүлийн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.

7.4.Энэ хуулийн 7.3-т зааснаас бусад анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн гэр бүлийн хэргийг тухайн хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн хамаарах нутаг дэвсгэрийн давж заалдах шатны шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.

7.5.Улсын дээд шүүх гэр бүлийн хэргийг хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ.

**8 дугаар зүйл.Нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа
/оршин байгаа/ нутаг дэвсгэрийн харьяаллаар
гаргах**

8.1.Гэр бүлийн хэргийн нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

**9 дүгээр зүйл.Нэхэмжлэгчийн сонгон авсан нутаг дэвсгэрийн
харьяалал**

9.1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйл, энэ хуулийн 9.2-т заасны дагуу нэхэмжлэгч энэ хуулийн 7.2-т заасан шүүхийг сонгосон бол энэ хуулийн 8.1-д заасан нутаг дэвсгэрийн харьяалал хамаарахгүй буюу нэхэмжлэгчийн сонгон авсан нутаг дэвсгэрийн харьяаллын шүүх хэргийг хянан шийдвэрлэнэ.

9.2.Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэл гаргах нэхэмжлэгч бага насны хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй, хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас хариуцагчийн байгаа газар очиход бэрхшээлтэй байвал нэхэмжлэлийг өөрийн оршин суугаа газрын нутаг дэвсгэрийн харьяалах шүүхэд гаргаж болно.

10 дугаар зүйл.Шүүхийн онцгой харьяалал

10.1.Бага насны, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд асрамж тогтоохтой холбоотой нэхэмжлэлийг хүүхдийн оршин байгаа газрын нутаг дэвсгэрийн харьяалах шүүхэд гаргана.

10.2.Тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбогдсон нэхэмжлэлийг нэхэмжлэгчийн оршин суугаа газрын нутаг дэвсгэрийн харьяалах шүүхэд гаргана.

10.3.Хүүхэд үрчлэлттэй холбоотой хүсэлтийг хүүхдийн оршин суугаа газрын нутаг дэвсгэрийн харьяалах шүүхэд гаргана.

10.4.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцуулах тухай хүсэлтийг асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийн оршин суугаа газрын нутаг дэвсгэрийн харьяалах шүүхэд гаргана.

10.5.Иргэнийг сураггүй алга болсонд тооцуулах буюу нас барсан гэж зарлуулах тухай хүсэлтийг уг иргэний сүүлчийн оршин сууж байсан газрын, хэрэв сүүлчийн оршин сууж байсан газар нь мэдэгдэхгүй бол сүүлчийн ажиллаж байсан газрын нутаг дэвсгэрийн харьяалах шүүхэд гаргана.

10.6.Сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй гэж тооцох болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцуулах хүсэлтийг уг иргэний оршин суугаа, эсхүл эмчлүүлж байгаа газрын нутаг дэвсгэрийн харьяалах шүүхэд гаргана.

10.7.Хорих ял эдэлж байгаа хүн нэхэмжлэл, хүсэлт гаргах, эсхүл хорих ял эдэлж байгаа хүнд холбогдуулан нэхэмжлэл, хүсэлт гаргах бол түүний ял эдэлж байгаа газрын нутаг дэвсгэрийн харьяалах шүүхэд гаргана.

10.8.Энэ зүйлд заасан гэр бүлийн хэргийн онцгой харьяаллыг зохигч хэлэлцэн өөрчилж болохгүй.

10.9.Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх хэргийн хүсэлтийг энэ хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 136 дугаар зүйлд заасны дагуу гаргана.

11 дүгээр зүйл.Хэргийн оролцогчийн хамтран ажиллах үүрэг

11.1.Хэргийн оролцогч үйл баримтыг тогтооход хамтран ажиллах үүрэгтэй.

11.2.Хэргийн оролцогч үйл баримтын талаар үнэн бөгөөд бүрэн мэдээлэл өгөх үүрэгтэй.

12 дугаар зүйл.Шүүх хуралдаан, хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааг хаалттай явуулах

12.1.Гэр бүлийн хэргийн шүүх хуралдаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дараах тохиолдолд хаалттай явуулна:

12.1.1.гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлтэй хэрэг;

12.1.2.шүүхийн журмаар эцэг, эх тогтоолгох нэхэмжлэлтэй хэрэг;

12.1.3.эцэг байх эрхийг хязгаарлах, хасуулах, эцэг, эх байх эрхийг хасах, сэргээх тухай нэхэмжлэлтэй хэрэг;

12.1.4.хүүхэд үрчлэлттэй холбоотой нэхэмжлэлийн шаардлага бүхий хэрэг;

12.1.5.асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбоотой нэхэмжлэлийн шаардлага бүхий хэрэг.

12.2.Энэ хуулийн 12.1-д зааснаас бусад тохиолдолд нээлттэй, ил тод явуулах нь хүний үндсэн эрхэд ноцтой хохирол учруулах үндэслэлтэй, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүх хэргийн оролцогчийн санал, эсхүл өөрийн санаачилгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулж болно.

12.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулах эсэхээс үл хамааран энэ хуулийн 6.1-д заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх хэргээс бусад гэр бүлийн хэргийн материалтай гагцхүү хэргийн оролцогч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч танилцах, хуулбарлан авах эрхтэй.

12.4.Хэргийн оролцогч бус этгээд энэ хуульд заасан хаалттай явуулах тохиолдлоос бусад гэр бүлийн хэргийн материалтай танилцах хүсэлт гаргасныг хангалттай үндэслэлтэй бөгөөд хэргийн оролцогч болон бусад этгээдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхгүй гэж шүүх үзвэл энэ хуулийн 12.3-т заасан хэргийн материалтай танилцахыг зөвшөөрч болно.

13 дугаар зүйл.Шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагч

13.1.Энэ хуульд заасан гэр бүлийн хэргийг анхан шатны журмаар шүүгч дангаар шийдвэрлэнэ.

13.2.Энэ хуулийн 6.4-т заасны дагуу гэрлэлт цуцлах нэхэмжлэлтэй хамт гэм хор, нөхөн төлбөр гаргуулах нэхэмжлэл гаргасан нь хэргийг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх үндэслэл болохгүй.

14 дүгээр зүйл.Зохигч шүүх хуралдаанд оролцох

14.1.Өмгөөлөгч оролцож байгаа эсэхээс үл хамааран зохигч шүүх хуралдаанд төлөөлөгчөөр дамжуулахгүйгээр өөрөө оролцох үүрэгтэй. Зохигч хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд шүүх хуралдаанд өөрөө оролцох үүргээ цахим хэлбэрээр хэрэгжүүлж болно. Цахим хэлбэрээр хэрэгжүүлж байгаа тохиолдолд зохигч байгаа нутаг дэвсгэрийн харьяалах анхан шатны шүүхийн байр, хэрэв хилийн чанадад байгаа бол тухайн улс дахь Дипломат төлөөлөгчийн газрын байрнаас, тухайн улс нь Дипломат төлөөлөгчийн газаргүй бол тухайн улсыг хавсран суугаа Дипломат төлөөлөгчийн газрын байрнаас тус тус шүүх хуралдаанд оролцоно.

14.2.Зохигч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 14.1-д заасны дагуу өөрөө оролцох боломжгүй бол төлөөлөгчөөр дамжуулан шүүх хуралдаанд оролцож болно. Зохигч өөр орон нутаг, хилийн чанадад байгаа нь шүүх хуралдаанд цахимаар оролцохгүй байх үндэслэл болохгүй.

14.3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлд заасан журмын дагуу шүүх хуралдааны товыг шүүхийн мэдэгдэх хуудсаар мэдэгдсэн боловч энэ хуулийн 14.1, 14.2-т заасан шүүх хуралдаанд оролцох журмыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зөрчсөн бол хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгч шийтгэвэр гарган зөрчил гаргасан зохигч, түүний төлөөлөгчийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй зохигчийг албадан ирүүлэх захирамж гаргаж болно. Энэ зөрчлийг давтан гаргасан бол шүүгч зөрчил бүрд арга хэмжээ авах эрхтэй.

14.4.Шүүхийн мэдэгдэх хуудаст энэ хуулийн 14.3-т заасан шүүх хуралдаанд ирээгүйгээс үүсэх үр дагаврыг тайлбарласан байна.

14.5.Зохигч, түүний төлөөлөгч шүүх хуралдаанд оролцоогүй нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол шүүх хуралдааныг хойшлуулж болно.

14.6.Хариуцагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй, шүүх энэ хуулийн 14.3-т заасны дагуу албадан ирүүлэх боломжгүй бол хэргийг хариуцагчийн эзгүйд хянан шийдвэрлэж болно. Нэхэмжлэгч ирээгүй тохиолдолд шүүгч нэхэмжлэлийг буцаана.

14.7.Хэргийн оролцогчийн эрхийг хамгаалах, эсхүл бусад зайлшгүй шалтгааны улмаас зохигчийн аль нэгийг шүүх хуралдааны танхимаас гаргаж шүүх хуралдааныг үргэлжлүүлж болно.

14.8.Энэ хуулийн 14.7-д заасны дагуу хэргийн оролцогч өөрийгөө байхгүйд хэрэг хянан шийдвэрлүүлэх хүсэлтээ бичгээр мэдэгдсэнийг үндэслэлтэй гэж шүүх үзвэл хүсэлт гаргасан хэргийн оролцогчийг оролцуулалгүйгээр хэргийг хянан шийдвэрлэж болно.

14.9.Эрх ашиг нь хөндөгдсөн этгээд энэ хуулийн 14.3-т заасан захирамжийн торгууль ногдуулсан хэсэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн

170.1-д заасны дагуу гомдол гаргах эрхтэй. Гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 171 дүгээр зүйлд заасан журмаар хянан шийдвэрлэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

15 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам

15.1.Энэ хуулийн 25.4-т зааснаас бусад гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлтэй хэргийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гэж үзнэ.

15.2.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан үндэслэлээр эвлэрүүлэн зуучлал дуусгавар болж, шүүхэд нэхэмжлэл гаргасан бол энэ хуульд заасны дагуу шүүх ердийн журмаар шийдвэрлэнэ.

16 дугаар зүйл.Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэл

16.1.Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлд гэрлэгчдийн овог, эцгийн нэр, нэр, гэрлэлтээ хэзээ, хаана бүртгүүлсэн, гэрлэлт цуцлуулах шалтгаан, насанд хүрээгүй хүүхэдтэй бол түүний нэр, төрсөн он, сар, өдөр, түүнчлэн насанд хүрээгүй хүүхдийг хүмүүжүүлэх, түүнд асрамж тогтоох, тэжээн тэтгэх болон эд хөрөнгийн талаарх хүсэлт, энэ талаар хоорондоо хэлэлцэн тохиролцсон гэрээ байгаа эсэхийг зааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана.

16.2.Хүүхдэд асрамж тогтоох, тэжээн тэтгэх, тусдаа амьдрах эцэг, эсхүл эх хүүхэдтэйгээ уулзах асуудлыг шүүх гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлтэй хамт шийдвэрлэнэ.

16.3.Гэрлэлт цуцлах үед эхнэр буюу нөхөр нь хүнд өвчтэй, хөдөлмөрийн чадваргүй, эдийн засгийн хувьд зайлшгүй туслалцаа шаардлагатайгаас тэтгэвэр гаргуулах, гэр бүлийн эд хөрөнгийн талаар гарсан маргааныг шүүх гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлтэй хамт шийдвэрлэж болно.

16.4.Хүүхэд долоо, түүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд түүний санал болон энэ хуульд заасан гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн үнэлгээний тайланг харгалзан үзнэ.

16.5.Энэ хуулийн 25.4.1-д заасан тохиолдолд гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүх шуурхай шийдвэрлэнэ.

17 дугаар зүйл.Гэрлэгчдийн эд хөрөнгийн болон тэжээн тэтгэх гэрээг биелүүлэх

17.1.Гэрлэгчид харилцан тохиролцож эд хөрөнгийн болон тэжээн тэтгэх тухай гэрээг тус тус байгуулсан бөгөөд тэдгээрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд аль нэг талын нэхэмжлэлээр эдгээр гэрээний биелэлттэй холбоотой маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ.

18 дугаар зүйл.Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ

18.1.Шүүгч шаардлагатай гэж үзвэл гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэхдээ дараах арга хэмжээг урьдчилан авахаар захирамж гаргаж болно:

18.1.1.насанд хүрээгүй хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эцэг, эхийг тэжээн тэтгүүлэх;

18.1.2.насанд хүрээгүй хүүхдийг эцэг, эхийн хэн нэг дээр байлгах;

18.1.3.гэрлэгчдийг тусдаа амьдрахыг даалгах;

18.1.4.энэ хуулийн 25.4.1-д заасан тохиолдолд гэрлэгчдийг уулзах болон аливаа хэлбэрээр харилцаа тогтоохоор оролдохыг, эсхүл гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй нөхцөлд байгаа гэрлэгчид аливаа хэлбэрээр ойртохыг хориглох;

18.1.5.гэрлэгч хэн нэгийг тэжээн тэтгүүлэх;

18.1.6.орон сууц болон хамтран өмчлөх дундын өмч, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, захиран зарцуулахыг хориглох;

18.1.7.шүүхийн зардлын зохих хувийг урьдчилгаа болгон төлүүлэх;

18.1.8.зохигчид эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрэх хугацаа заах.

19 дүгээр зүйл. Гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлах

19.1.Хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүгч шаардлагатай гэж үзвэл дараах ажиллагааг өөрийн санаачилгаар явуулна:

19.1.1.гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийхийг энэ хуулийн 20.1-д заасан гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчид даалгах тухай захирамж гаргах;

19.1.2.холбогдох байгууллага, хувь хүнээс дансны мэдээлэл, хөрөнгийн байдал, орлого, боловсролын байдал болон бусад шаардлагатай мэдээлэл, лавлагаа, тодорхойлолтыг гаргуулах, холбогдох этгээдээс мэдүүлэг авах;

19.1.3.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн⁵ 31 дүгээр зүйлд заасан аюулын зэргийн үнэлгээ, мөн хуулийн 32 дугаар зүйлд заасан нөхцөл байдлын үнэлгээг холбогдох этгээдээр хийлгүүлэхээр даалгах тухай захирамж гаргах.

19.2.Энэ хуулийн 19.1.1-д заасан шинжээчид даалгасан шүүгчийн захирамж гарснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.

19.3.Энэ хуулийн 19.1.1-д заасан шүүгчийн захирамжид Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170.1-д заасан журмаар гомдол гаргахгүй.

19.4.Энэ хуулийн 19.1.1-д заасан үнэлгээний тайланг шүүгчид ирүүлсэн тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 80.3-т заасны дагуу шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээсэн захирамжид Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170.1-д заасны дагуу гомдол гаргахгүй.

⁵ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 05 дугаарт нийтлэгдсэн.

20 дугаар зүйл.Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч

20.1.Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч нь гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судалж, үнэлгээ хийх чиг үүрэг бүхий шүүхийн ажилтан байна.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчид дараах шаардлага тавигдана:

20.2.1.25 насанд хүрсэн;

20.2.2.сэтгэл судлал, боловсрол, нийгмийн хамгаалал, эсхүл социологийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй;

20.2.3.энэ хуулийн 20.2.2-т заасан мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан;

20.2.4.эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй.

20.3.Энэ хуулийн 20.1-д заасан гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч нь энэ хуулийн 19.1.1-д заасны дагуу гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг 21 хоногийн дотор хийж, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийсэн тухай тайланг шүүхэд хүргүүлнэ.

20.4.Энэ хуулийн 20.1-д заасан гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч нь гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлахдаа хараат бус байх зарчмыг баримтлах бөгөөд нууц хадгалах, задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

21 дүгээр зүйл.Татгалзан гарах үндэслэл

21.1.Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч дараах үндэслэл байвал гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлахгүй:

21.1.1.хэргийн оролцогчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн бол;

21.1.2.хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, түүнчлэн уг гэр бүлийн нөхцөл байдлыг шударгаар шинжлэн судалж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал;

21.1.3.ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон бол.

21.2.Энэ хуулийн 21.1-д зааснаас бусад үндэслэлээр гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийг татгалзаж болохгүй.

22 дугаар зүйл.Татгалзан гарах хүсэлт гаргах

22.1.Энэ хуулийн 21.1-д заасан татгалзан гарах үндэслэл байвал гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч энэ хуулийн 19.1.1-д заасан шүүгчийн захирамжийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор татгалзан гарах тухай мэдэгдэнэ.

22.2.Хэргийн оролцогч гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийг энэ хуулийн 21.1-д заасан татгалзан гаргах үндэслэлтэй гэж үзвэл энэ талаарх хүсэлтийг шүүхэд гаргана.

22.3.Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийг татгалзан гаргах тухай асуудлыг шүүгч шийдвэрлэж, захирамж гаргана.

23 дугаар зүйл.Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн үнэлгээний тайлан

23.1.Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч нь гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судалж, үнэлэхдээ асуулт асуух, ярилцлага хийх, холбогдох байгууллагаас лавлагаа, тодорхойлолт гаргуулах зэргээр тухайн нөхцөл байдлыг тал бүрээс нь судлах бөгөөд дараах асуудлыг заавал судлан үнэлгээний тайланд тусгана:

23.1.1.маргааны шалтгаан, нөхцөл, талуудын хүсэл зориг, байр суурь;

23.1.2.гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгө, өр төлбөр, авлага, орлого, зарлага гэх зэрэг санхүүгийн байдал;

23.1.3.дундын эд хөрөнгийн асуудлаар маргаантай бол хэрхэн хуваах талаарх тохиролцоо, хүсэл зориг;

23.1.4.хүүхдийг хэний асрамжид үлдээх талаар харилцан тохиролцоогүй бол гэрлэгчдийн эрүүл мэнд, сэтгэлзүй, зан араншин, хүүхдийг өөрийн асрамжид үлдээхэд нөлөөлөх нөхцөл байдал, хүчин зүйл, хүүхэдтэй уулзах боломж;

23.1.5.долоо, түүнээс дээш насны хүүхэдтэй хийсэн ярилцлага;

23.1.6.хүүхдийн онцлог байдал, шаардлагатай бол сурган хүмүүжүүлэгчийн энэ талаарх дүгнэлт;

23.1.7.талууд эвлэрэх боломжтой эсэх талаарх санал.

23.2.Энэ хуулийн 23.1.1-д заасан үнэлгээ хийх журмыг Улсын дээд шүүх батална.

23.3.Энэ хуулийн 23.1.1-д заасан үнэлгээний тайланд талууд гомдол гаргах эрхгүй.

23.4.Энэ хуулийн 23.1-д заасан үнэлгээний тайлангаас тодруулах, нэмэлт дүгнэлт гаргуулах шаардлагатай гэж үзвэл шүүх энэ талаар асуулт, шаардлага тавьж гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчид хугацаа тогтоон хүргүүлж болно. Шүүгч үнэлгээний тайланг шийдвэр гаргахдаа харгалзан үзнэ.

23.5.Энэ хуулийн 23.1.5-д заасны дагуу хүүхэдтэй хийсэн ярилцлагыг түүний эцэг, эх тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид танилцуулахыг хориглоно.

24 дүгээр зүйл.Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох, дуусгавар болгох

24.1.Шүүгч гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээг зохигчийн хүсэлтээр өөрчлөх, эсхүл хүчингүй болгож болно.

24.2.Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээг дараах нөхцөлд дуусгавар болсонд тооцно:

24.2.1.гэрлэгчид эвлэрч, шүүгч эвлэрлийг баталсан захирамж гаргаж хэргийг хэрэгсэхгүй болгосон;

24.2.2.гэрлэлт цуцлах, тэжээн тэтгэхтэй холбогдсон хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр гарсан.

25 дугаар зүйл.Гэрлэлт цуцлах тухай хэрэг хянан шийдвэрлэх

25.1.Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна.

25.2.Энэ хуулийн 25.1-д заасан эвлэрүүлэх арга хэмжээг зөвхөн нэг удаа хэрэглэнэ. Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон нь шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн хэрэгт эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахаас татгалзах үндэслэл болохгүй.

25.3.Гэрлэгчид эвлэрвэл шүүгч эвлэрлийг баталсан захирамж гаргаж хэргийг хэрэгсэхгүй болгоно.

25.4.Энэ хуулийн 25.1-д заасан арга хэмжээг дараах тохиолдолд шүүгч авахгүйгээр гэрлэлтийг цуцалж болно:

25.4.1.гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон;

25.4.2.гэрлэгчид бие биенээсээ тусдаа амьдраад таван жил болсон бөгөөд бага насны хүүхэдгүй, гэрлэлт цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн;

25.4.3.эд хөрөнгийн маргаантай боловч 18-аас доош насны хүүхэдгүй гэрлэгчид гэрлэлт цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн.

25.5.Гэрлэгчид шүүхээс эвлэрүүлэх арга хэмжээ авсан хугацаанд эвлэрээгүй бол шүүгч гэрлэлт цуцлах шийдвэр гаргана.

25.6.Гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваах маргааныг нэхэмжлэлийг үндэслэн хянан шийдвэрлэнэ.

25.7.Шүүх нэхэмжлэлийг хангавал гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргана.

26 дугаар зүйл.Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх хэргийн хүсэлт

26.1.Энэ хуулийн 6.1-д заасан хэргийн талаарх хүсэлтэд зорилго, шалтгаан, үндэслэлийг тодорхой тусгаж, холбогдох нотлох баримтыг хавсаргана.

27 дугаар зүйл.Иргэнийг сураггүй алга болсонд тооцуулах буюу нас барсан гэж зарлуулах тухай хүсэлт хүлээн авсан шүүгчийн үйл ажиллагаа

27.1.Хүсэлт хүлээн авсан шүүгч алга болсон иргэний талаар мэдээ өгч чадах хүн /төрөл садан, хамт ажиллаж, сурч байсан/ байгаа эсэхийг тодруулж, сураггүй алга болсон иргэний талаар түүний оршин сууж байсан болон ажиллаж байсан газрын зохих байгууллагад холбогдох баримт, мэдээ байгаа эсэхийг лавлана.

27.2.Шүүгч шаардлагатай гэж үзвэл цагдаагийн байгууллагаар дамжуулан уг иргэнийг эрэн сурвалжлах арга хэмжээ авахуулах бөгөөд түүний эд хөрөнгөд эрхлэн хамгаалалт тогтоож болно.

28 дугаар зүйл.Иргэнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах тухай хэрэг хянан шийдвэрлэх

28.1.Иргэнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах тухай хэргийг шүүгч хянан шийдвэрлэхдээ хүсэлт гаргасан этгээдийг оролцуулна.

28.2.Шүүгч иргэнийг сураггүй алга болсонд тооцож, шийдвэртээ түүний эд хөрөнгөд эрхлэн хамгаалалт тогтоохоор заана.

28.3.Иргэнийг нас барсан гэж зарласан шийдвэр гарсны дараа иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд зохих тэмдэглэл хийлгэхээр шийдвэр гаргасан шүүх улсын бүртгэлийн байгууллагад уг шийдвэрийг явуулна.

29 дүгээр зүйл.Иргэнийг сураггүй алга болсонд тооцсон буюу нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох

29.1.Сураггүй алга болсонд тооцогдсон буюу нас барсан гэж зарлагдсан иргэн хүрэлцэн ирэх буюу байгаа газар нь мэдэгдвэл тухайн шүүх шинээр шийдвэр гаргаж урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болгоно.

29.2.Шинэ шийдвэрээр уг иргэний эд хөрөнгөд тогтоосон эрхлэн хамгаалалтыг өөрчилж, иргэний улсын бүртгэлд тэмдэглэсэн тэмдэглэлийг хүчингүй болгон түүнийг биелүүлэхийг холбогдох байгууллагад даалгана.

30 дугаар зүйл.Иргэнийг хязгаарлагдмал чадамжтай, эсхүл эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай хүсэлт гаргах

30.1.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлуулах тухай сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцуулах тухай хүсэлтийг уг иргэний гэр бүлийн гишүүн, эсхүл сонгуулийн хороо, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, асран хамгаалах байгууллага, эрүүл мэндийн байгууллага шүүхэд гаргана.

31 дүгээр зүйл.Иргэнийг хязгаарлагдмал чадамжтай, эсхүл эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай хэрэг хянан шийдвэрлэх

31.1.Хүсэлт хүлээн авсан шүүх нь сэтгэцийн эмгэг судлалын шинжээч томилон шинжилгээ хийлгэж, тухайн иргэний сэтгэцийн байдал, өөрийн үйл ажиллагааны учир холбогдлыг ойлгох, өөрийгөө зөв удирдаж чадах эсэх талаар дүгнэлт гаргуулна.

31.2.Шинжилгээ хийлгэхээс зайлсхийсэн этгээдэд шүүгчийн захирамжийн дагуу албадан шинжилгээ хийлгэж болно.

31.3.Шүүгч хэргийг хянан шийдвэрлэхдээ асран хамгаалах байгууллагын төлөөлөгч, харгалзан дэмжвэл буюу асран хамгаалбал зохих этгээдийг шүүх хуралдаанд оролцуулж болно.

32 дугаар зүйл.Иргэнийг хязгаарлагдмал чадамжтай, эсхүл эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай шийдвэр

32.1.Шүүх шинжээчийн дүгнэлт, бусад нөхцөл байдлыг үндэслэн тухайн иргэнийг хязгаарлагдмал чадамжтай, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож уг иргэнд харгалзан дэмжилт, асран хамгаалалтыг тогтооно.

32.2.Хязгаарлагдмал чадамжтай, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон иргэн эдгэрэх буюу эрүүл мэнд нь мэдэгдэхүйц сайжирвал уг иргэн, түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч түүнчлэн энэ хуулийн 29.1-д заасан этгээдийн хүсэлтийн дагуу шүүх сэтгэцийн эмгэг судлалын шинжээчийн дүгнэлтийг үндэслэн уг иргэн эрх зүйн бүрэн чадамжтай болсон тухай шийдвэр гаргаж болно.

32.3.Энэ хуулийн 32.2-т заасан шийдвэр гарсны дараа уг хүнд тогтоосон харгалзан дэмжилт, асран хамгаалалтыг хүчингүй болсонд тооцсон шийдвэр гаргана.

33 дугаар зүйл.Иргэнийг хязгаарлагдмал чадамжтай, эсхүл эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шүүхийн зардал

33.1.Иргэнийг мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай, эсхүл сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарах шүүхийн зардлыг төр хариуцна.

33.2.Сэтгэцийн талаар эрүүл гэдгийг мэдсээр байж иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлуулах буюу хасуулахын тулд энэ хуулийн 31.1-д заасан хүсэлт гаргасан нь тогтоогдвол шүүхийн бүх зардлыг буруутай этгээдээс гаргуулна.

34 дүгээр зүйл.Хүүхэд үрчлэлттэй холбоотой хүсэлт гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

34.1.Хүүхэд үрчлэлттэй холбоотой хэргийг хянан хэлэлцэхдээ үрчлүүлэгч, үрчлэн авагч талуудыг шүүх хуралдаанд оролцуулна.

34.2.Шүүх нэхэмжлэлийг хангавал хүүхэд үрчлүүлэх тухай, эсхүл хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох тухай шийдвэр гаргана.

34.3.Шүүх энэ хуулийн 34.2-т зааснаар үрчлэлтийг хүчингүй болгосон бол хүүхдийг төрүүлсэн эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгч тэдгээр нь байхгүй бол хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ГЭР БҮЛИЙН ХЭРГИЙГ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГАА

35 дугаар зүйл.Шүүхийн эвлэрүүлэн зуучлал

35.1.Энэ хуулийн 15.1-д заасан шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болж, шүүхэд гэр бүлийн хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн хэрэгт эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахад энэ бүлэгт заасан журам үйлчилнэ.

35.2.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6.3-т заасан эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд энэ бүлэг хамаарахгүй.

35.3.Энэ хуулийн 25.1-д заасны дагуу хэрэг үүсгэсэн шүүгч шаардлагатай гэж үзвэл, эсхүл энэ хуулийн 23.1-д заасан гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн үнэлгээний тайлангаар талуудыг эвлэрүүлэх боломжтой гэж үзсэн бол талуудыг эвлэрүүлэх арга хэмжээ авахаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлах багт хэргийг шилжүүлэх тухай шүүгчийн захирамж гаргана.

35.4.Энэ хуулийн 35.3-т заасан шүүгчийн захирамжийн үндэслэх хэсэгт шүүгч гэрлэгчдийн эвлэрэх боломж, үндэслэлийн талаар тусгах ба шаардлагатай гэж үзвэл эвлэрүүлэн зуучлах баг түүний захирамжийн үндэслэлээс тодруулан ярилцаж болно. Энэ ярилцлагын явцад тэмдэглэл хөтлөхгүй байж болно.

35.5.Гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээний тайлан гаргасан бол тус тайланг энэ хуулийн 35.3-т заасан шүүгчийн захирамжид хавсаргана.

36 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах баг

36.1.Эвлэрүүлэн зуучлах баг нь эвлэрүүлэн зуучлалын шүүгч, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, орон тооны бус гишүүнээс бүрдэнэ.

36.2.Эвлэрүүлэн зуучлалын шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс томилно.

36.3.Эвлэрүүлэн зуучлах баг 30 хоногоос илүүгүй хугацаанд эвлэрүүлэх ажиллагааг явуулна.

37 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах багийн орон тооны бус гишүүн

37.1.Эвлэрүүлэн зуучлах багийн орон тооны бус гишүүн нь эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өр төлбөргүй, ёс суртахууны хувьд нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, гэр бүлтэй иргэн байна.

37.2.Энэ хуулийн 37.1-д заасан эвлэрүүлэн зуучлах багийн орон тооны бус гишүүнийг хоёр жилийн хугацаагаар гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага томилно.

37.3.Энэ хуулийн 37.1-д заасан эвлэрүүлэн зуучлах багийн орон тооны бус гишүүн нь эвлэрүүлэн зуучлалын багт ажилласны урамшууллыг гэр бүл, хөдөлмөр,

нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгоно. Орон тооны бус гишүүн урамшуулал авахаас татгалзаж болно.

37.4.Энэ хуулийн 37.3-т заасан урамшуулал хэмжээг гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

38 дугаар зүйл.Эвлэрүүлэх хуралдааны бэлтгэл хангах

38.1.Хэргийг эвлэрүүлэх хуралдаанаар хэлэлцэхтэй холбогдуулан эвлэрүүлэн зуучлагч шүүгч дараах бэлтгэл ажиллагаа явуулна:

38.1.1.эвлэрүүлэх хуралдаан хэзээ, хаана болохыг талуудад шүүхийн мэдэгдэх хуудсаар мэдэгдэх;

38.1.2.шаардлагатай гэж үзвэл эвлэрүүлэх хуралдаанаас өмнө гэрлэгчдийг сэтгэлзүйчтэй уулзуулах арга хэмжээ авах;

38.1.3.эвлэрүүлэн зуучлалын багийн гишүүдтэй бэлтгэл уулзалт хийж, эвлэрүүлэх хуралдааны дэг, хуралдааны явцад хөндөх асуудлын дараалал, ярилцах арга зүйг судалгааны үндэстэй тодорхойлох.

38.2.Эвлэрүүлэх хуралдаан даргалагчийг энэ хуулийн 38.1.3-т заасан уулзалтаар багийн гишүүдийн олонхын саналаар сонгоно.

39 дүгээр зүйл.Эвлэрүүлэх хуралдаан

39.1.Эвлэрүүлэх хуралдааны явцад хөндөгдсөн асуудал, гэрлэгчдийн байр суурийг хэргийг хянан шийдвэрлэхэд нотлох баримтаар үнэлэхгүй бөгөөд хүүхэдтэй хийсэн ярилцлагыг түүний эцэг, эх тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид танилцуулахыг хориглоно.

39.2.Эвлэрүүлэх хуралдааныг нэг удаа хийх бөгөөд дахин хуралдуулах хүсэлтийг гэрлэгчид нэгэн адил гаргавал хоёр дахь хуралдааныг хийж болно.

39.3.Эвлэрүүлэх хуралдаанаас дэлгэрэнгүй ба хураангуй тэмдэглэл гарна. Дэлгэрэнгүй тэмдэглэлийг хуралдааны нарийн бичгийн дарга хөтөлнө. Хураангуй тэмдэглэлийг энэ хуулийн 39.2-т заасан сүүлийн хуралдаанаас гаргах ба гэрлэгч эвлэрсэн, эсхүл эвлэрээгүй талаар дурдсан байна. Хураангуй тэмдэглэлийг эвлэрүүлэх хуралдааны даргалагч үйлдэнэ.

39.4.Эвлэрүүлэх хуралдааны дүнд зохигч гэрлэлт цуцлах асуудлаар эвлэрсэн, эсхүл эвлэрээгүй тухай, эсхүл гэрлэлт цуцлахаас бусад асуудлаар эвлэрсэн бол энэ талаар хураангуй тэмдэглэлд тусгаж хэрэг хянан шийдвэрлэх шүүгчид хүргүүлнэ. Шүүгч тэмдэглэлийг хүлээн авснаар шүүх хуралдааныг зарлан хуралдуулна.

39.5.Шүүгч энэ хуулийн 39.4-т заасан хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанаар зохигчийн эвлэрэх хүсэлт хэвээр байгаа эсэхийг тодруулж, зохигчид нэгэн адил хүсэлтээ дэмжиж байгаа бол шүүгч эвлэрлийг баталсан захирамж гаргаж, хэргийг хэрэгсэхгүй болгоно.

39.6.Энэ хуулийн 35.3-т заасан эвлэрүүлэх ажиллагааны хүрээнд гэрлэгчид эвлэрээгүй боловч гэрлэгчдийн хооронд үүссэн гэрлэлт цуцлахаас бусад тэтгэвэр, тэтгэлэг, тэтгэмж, хүүхдийн асрамж, тусдаа амьдрах эцэг, эсхүл эх нь хүүхэдтэйгээ уулзах уулзалт тогтоох, дундын хөрөнгө хуваахтай холбоотой асуудлаар гэрлэгчдийг харилцан тохиролцоход эвлэрүүлэн зуучилж болно.

39.7.Гэрлэгчид энэ хуулийн 39.6-д заасан асуудлаар харилцан тохиролцсон нь хуульд нийцсэн гэж үзвэл хэрэг үүсгэсэн шүүгч гэрлэлт цуцлах тухай шийдвэрт энэ талаар тусгана.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД

40 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

40.1.Энэ хуулийг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг